



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТСҮХ ТАНАА

2022. 05. 20 № 03/1117
танай _____ -ны № _____ -т

Тогтоол хүргүүлэх тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан тушаалын тодорхойлолтод зөвшөөрөл авахаар ирүүлснийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

“Зөвшөөрөл олгох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 323 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Зөвшөөрлийг үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг баталсан шийдвэрээ ирүүлнэ үү.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА

2203-011



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Г Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захиргачийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захиргачийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" 360 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хяналт үнэлгээ, статистик судалгаа, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Жуулчны аюулгүй байдал, үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Эвент хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлахыг нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга /Д.Батсүх/-д зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга /Д.Батсүх/-д үүрэг болгосугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4.Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх Салбар зөвлөл (Т.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ